



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 07 сарын 29 өдөр

Дугаар А/411

Есөнбулаг сум

Эзэмшил газрын байршил,
хэмжээ, зориулалт өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг, 27.3 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.10.2, 29.10.3, 29.10.5, 29.10.6 дахь заалт, 42 дугаар зүйлийн 42.4 дэх хэсэг, Хот байгуулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Есөнбулаг сумын Жаргалант багт "10 км авто зам тавих" ажлын хүрээнд нөлөөлөлд өртсөн иргэн Галсангийн Цэцгээ (ДЙ56040805)-ийн гэр, орон сууцны хашааны газрын зориулалтаар эзэмшиж байгаа 8208005483 нэгж талбарын дугаартай газрын байршил, хэмжээ, зориулалтыг өөрчилж 1-2 дугаар хавсралтаар баталж эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшсэн Галсангийн Цэцгээ (ДЙ56040805)-ийн газрын мэдээллийг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд бүртгэн, газар эзэмшигч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж буй байдалд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (А.Алтанхуяг)-т даалгасугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын засаг даргын 2018 оны А/63 дугаар захирамжийн Г.Цэцгээд холбогдох 2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

Имийн Засаг даргын 2026 оны
сарын 25-ны өдрийн 44 дүгээр
мөрийн хөрөнгөөр хавсралт

Toll-free 800-942

—○○○—